



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

Багш хөгжлийн төв, 11 баг, 6-р хороо,
Дархан сум, Дархан-Уул аймаг 45059
Утас/факс: (976) 7037-0011
Цахим шуудан: dca@da.mong.gov.mn

2024. 01. 29 № 01/36
танай 2024.01.25 -ны № 4/205 -т


СОЁЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2024 оны
01 дүгээр албан даалгаврын 7.18 дахь заалт
Монгол Улсыг гадаад сурталчлах, түгээн
дэлгэрүүлэх "Go Mongolia" арга хэмжээний
хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг
хүргүүлж байна.

Хавсралт.....³хуудастай.

ДАРГА

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ



4524010057

2024-A5-Явсан Бичиг.Досх

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

“GO MONGOLIA” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН


2024.01.29

Дархан-Уул аймаг

Монгол Улсын Ерөнхий Сайдын “2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Тус газар нь Монгол Улсыг гадаадад сурталчлах, таниулах “Go Mongolia” арга хэмжээ болон албан даалгаврын хэрэгжилтийг хяналтад авч ажиллахыг харьяа соёлын байгууллагууддаа 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор чиглэл хүргүүлж ажилласан.

“Go Mongolia” үндэсний брэндийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, таниулах зэрэг зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, зурагт хуудсыг байгууллагын сайт болон цахимд тогтмол байршуулж төрийн болон төрийн бус байгууллагууд, тус аймгийн иргэд олон нийтэд сурталчилан ажиллалаа.



2. Тус газар нь соёлын аялал, жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Дархан хотын Соёл, амралтын хүрээлэн, Залуучууд театр, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд “Бурхантын өвлийн наадам”-ыг зохион байгууллаа. Үүнд:

-“Хойд бүсийн мөсөн сурын чуулга харваа-2024” тэмцээнийг “Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн”-д зохион байгуулав. Тус тэмцээнд 12 аймгийн 216 харваач оролцож цэц мэргэнээ сорьсон бөгөөд Цуваа харвааны төрөлд 10 байр, Багийн харвааны төрөлд 3 байр тус тус эзлүүлж шагнаж урамшууллаа.



-**"Darkhan ice drift-2024"** мөсний дрифтын тэмцээнийг Улаанбаатар, Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт аймгуудын 69 тамирчдын дунд зохион байгууллаа.




-**"Дархан цом-2024 аймгийн мөсний спорт загасчлалын тэмцээн"**-д 6 багийн 30 гаруй тамирчид 2 төрлөөр оролцож 100 гаруй үзэгч үзэж сонирхлоо.




-**"Бурхантын өвлийн наадам"**-ын үеэр 2 өдөр **"Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн"**-д **агаарын бөмбөлөг** хөөргөлөө. Тус агаарын бөмбөлөгөөр 220 гаруй иргэд үйлчлүүллээ.



ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Б.ДОЛГОРМАА

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА  Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

